

ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ГАДНА ОРЧНЫ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН 20 ... ОНЫ БҮРТГЭЛ

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль жил бүрийн
12-р сарын 20-ны дотор дүүргийн Боловсролын хэлтэст
цаасаар хүргүүлнэ.

1. Хаягийн хэсэг

Байгууллагын нэр:

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--

КОД

Дүүргийн нэр:

--	--

Хорооны дугаар:

--	--

2. Мэдээллийн хэсэг

2.1. Гадна орчны гэрэлтүүлэгтэй шонгийн тоо		
2.2. Теле хяналтын камерын тоо		
2.3. Явган хүний замын урт, м		
2.4. Ногоон байгууламж, м ²		
2.5. Хогийн савны тоо		

- 2.6. Хөдөлгөөний аюулгүй байдлын тэмдэгтэй эсэх Тийм - 1 Үгүй - 2
- 2.7. Гарцын тэмдэглэгээтэй эсэх Тийм - 1 Үгүй - 2
- 2.8. Хурд сааруулагчтай эсэх Тийм - 1 Үгүй - 2

Бүртгэсэн: Албан тушаал:

Гарын үсэг: \

Тамга\тэмдэг

Хянасан: Албан тушаал:

Гарын үсэг: \

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн гадна орчны эрүүл, аюулгүй байдлын бүртгэлийн маягт (ЭАБ-12а) - ыг нөхөх заавар

Энэ бүртгэлийг цэцэрлэг, сургуулийн ажилтан тухайн жилийн 12 сарын 15-ны өдрөөр тасалбар болгон мэдээллийг гарган, тогтоосон хугацаанд дүүргийн Боловсролын хэлтэст маягтаар хүргүүлнэ.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ:

Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- 01, Багахангай дүүрэг- 04, Баянгол дүүрэг- 07, Баянзүрх дүүрэг- 10, Налайх дүүрэг- 13, Сонгинохайрхан дүүрэг- 16, Сүхбаатар дүүрэг- 19, Хан-Уул дүүрэг- 22, Чингэлтэй дүүрэг- 25 гэсэн кодыг зохих нүдэнд бөглөнө. Хорооны дугаарыг бичиж, кодыг "Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр"-ийг нөхөх заавар болон "Хүн ам" мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (утас - 328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон ubstat.mn цахим хуудсаас энэ кодыг мэдэх боломжтой.

2. МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ:

Сургууль, цэцэрлэгийн гадна орчин гэдэг нь зөвхөн байгууллагын хашаан доторх хэсэг байна. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хашаанаас гадуур байгаа гэрэлтүүлэг, телекамер, явган зам, ногоон байгууламж, хогийн сав, авто замын аюулгүй байдлын тэмдэглэгээ, хурд сааруулагч зэрэг нь тухайн хороо, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны үнэлгээнд хамаарна.

2.1-т тухайн цэцэрлэг, сургуулийн хашаан доторх хэсгийн нийт асдаг гэрэлтүүлгийн шонгийн тоог бичнэ.

2.2-т цэцэрлэг, сургуулийн хашаан дотор болон орох орц, гарцын хэсэгт байрлуулсан теле хяналтын камерын тоог бичнэ.

2.3-т цэцэрлэг, сургуулийн хашаан дотор тавьсан явган хүний замын уртыг метрээр илэрхийлэн бичнэ.

2.4-т цэцэрлэг, сургуулийн хашаан дотор байгаа зүлэгжүүлж, мод, бут сөөг, цэцгийн мандал тарьсан, зориулалтын хавтан суулгаж тохижуулсан ногоон байгууламжийн талбайн хэмжээг метр квадратаар илэрхийлэн бичнэ. Харин зүлэггүй болсон, хавтан нь эвдэрсэн зэрэг арчилгаагүй ногоон байгууламжийн хэмжээг оруулахгүй.

2.5-д цэцэрлэг, сургуулийн хашаа дотор байрлуулсан хогийн савны тоог бичнэ.

2.6-д цэцэрлэг, сургууль руу чиглэсэн болон сургуулийн хажуугаар явсан автозам дээр байршуулсан хөдөлгөөний аюулгүй байдлын тэмдэглэгээ байвал тийм (1), байхгүй бол үгүй (2) гэсэн кодыг нөхнө.

2.7-д цэцэрлэг, сургууль руу чиглэсэн болон сургуулийн хажуугаар явсан автозам дээр байршуулсан гарцын тэмдэглэгээ байвал тийм (1), байхгүй бол үгүй (2) гэсэн кодыг нөхнө.

2.8-д цэцэрлэг, сургууль руу чиглэсэн болон сургуулийн хажуугаар явсан автозам дээр байршуулсан хурд сааруулагч байвал тийм (1), байхгүй бол үгүй (2) гэсэн кодыг нөхнө.

Тухайн хорооны нутаг дэвсгэрт байрлаж буй сургууль, цэцэрлэгийн тоо их бол маягтын дагуу нэмэлт хуудас хэрэглэнэ. Нэмэлт хуудас бүрийг заавал дугаарлана.